

**Сонгодог монгол бичгийн хэл буюу
монгол сударын хэлний зарим онцлогоос***

Ц. Шагдарсүрэн (МУИС)

Үүнийг бичигч хэдэн жилийн өмнө нийтлүүлсэн "Монгол хэлний хөгжлийн эртний үе, түүнийг судласан тойм" гэдэг томоохон өгүүлэлдээ Сонгодог монгол бичгийн хэлний талаар доор өгүүлэх санааг анх хөндөж зарим зарим жишээ баримтыг харьцуулан үзэнгээ "Сонгодог монгол бичгийн хэл"-ний талаар дараа тусхайлан бичихээ амласан учир энэхүү өгүүллийг толилуулж байна¹.

Аливаа нэгэн хэл бичгийн хөгжлийг үечлэнэ гэдэг нь тухайн судлагдахууны хувьд харьцангуй бие даасан бүхэл бүтэн үеийг өмнөхи болон дараагийнхи нь үеэс ялган өгч чадахуйц гол гол онцлогий нь тодруулж өгнө гэсэн хэрэг бөлгөө. Монгол хэлний судлагааны хүрээнд зарим судлагчийн бичсэнийг авч үзэхүл монгол хэл бичгийн хувьд өвөр зуураа илэрхий ялгаатай хэд хэдэн судлагдахууны үечлэлийг хооронд нь хольж хутгасан байдал цөөнгүй харагддаг билээ. Тийм учраас монгол хэл бичгийн түүхэн судлалын хүрээнд үечлэн авч үзэхдээ наад зах нь дараахи хэдэн судлагдахууны мөн чанарыг зайлашгүй ялган салгах шаардалгатай гэдгийг энэ далимд тэмдэглэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

Монгол хэлний хөгжлийн үечлэл;
Монгол бичгийн хөгжлийн үечлэл;
Монгол бичгийн хэлний хөгжлийн үечлэл

* Эл сэдэвээр зохиогч 2001 оны 5-р сард Японы Монголсудлалын нийгэмлигийн хуралд илтгэл тавьсан бөгөөд энэхүү өгүүлэл бүрэн эхээрээ уг нийгэмлигийн *Bulletin of Japanese Association for Mongolian Studies* сэтгүүлд [No. 32 (2002) pp. 41-54] Mukai Shin'ichi-гийн орчуулгаар японоор гарсан болно. Энэхүү монгол эхэд зарим нэг холбогдох баримт жишээг нэмэн оруулсан бөлгөө.

¹ Ц. Шагдарсүрэн, *Монгол хэлний хөгжлийн эртний үе, түүнийг судласан тойм*, - *Mongolian Studies* (The Korean Association for Mongol Studies), N. 6 (1993), Seoul, 1999, pp. 61-139.

зэрэг олон асуудалыг тус тусынхи нь хүрээнд авч үзвэл зохилтой бөгөөд эдгээр судлагдахуун тус бүрийн үечлэл нь өөр өөрийн онцлог шинжтэй нь мэдээж бөлгөө.

Харин одоогийн байдлаар дээр дурдсан гурван өөр үечлэлийн дотроос Б. Я. Владимирцов (1929), Л. Лигети (L. Ligeti, 1953), Н. Поппе (N. Poppe, 1955), Б. Ринчен (1964-1968), Д. Төмөртоогоо (1992), Ц. Шагдарсүрэн (1999)² зэрэг гадаад дотоодын олон эрдэмтэн эхний буюу монгол хэлний хөгжлийн үечлэлийн асуудлыг анхаарч өөрийн гэсэн санал дүгнэлтээ дэвшүүлэн гаргажээ.

Монгол бичгийн хөгжлийг үечлэхэд бичгийн хэлбэр болон зөв бичихзүйн асуудал шууд холбогдох бөгөөд энэ талаар бусад ажлын далимд хэсэг бусаг дурдсан зүйл буй³ боловч энэ талаар нэгэн цогцод нь авч үзсэн буюу тусхайлан бие даан гарсан бүтээл үндсэндээ алга байна. Тэдгээр хэсэг бусаг дурдсан зүйлийн дотор, ялангуяа цаг хугацааны эрхээр түрүү үеийн судлагчдын дүгнэлтэд ч одоо эргэж нягтлууштай санаа гарч буй бөгөөд энэ талаар тусгайлан өгүүлэх болно.

Харин монгол бичгийн хэлний хөгжлийн асуудлыг ерөнхийд нь болон янз бүрийн талаас нь судласан бүтээл олон гарсан бөгөөд академич Б. Я. Владимирцов (1929), Н. Поппе (1964) нар анх гурав үечлэсэн байх боловч өнөөдрийн монгол хэлшинжлэлийн хүрээнд монгол бичгийн хэлийг ерөнхийд нь:

Сонгодог монгол бичгийн хэлний өмнөхи үе,
Сонгодог монгол бичгийн хэлний үе

хэмээн Сонгодог монгол бичгийн хэл гэдэг нэр томъёог үндэс болгон хуваан үзэх явдал түлхүү ажиглагдах бөгөөд тус бүрт нь тусхайлан нэрлэж зориулсан судлагааны бие даасан томоохон бүтээл ч гарчээ⁴. Ийнхүү үечлэж хуваан үзэхдээ гол төлөв найруулгын талыг илүүтэй анхаарсан байдаг тул ямар нэгэн хэмжээгээр эргэн нягтлууштай зүйл буй гэж хэлж болно. Учир нь, монгол бичгийн хэлийг Сонгодог монгол бичгийн хэлний өмнөхи үе, Сонгодог монгол бичгийн хэл хэмээн хувааж үзэх нь нэгд, нэр томъёоны хувьд, харьцангуй хожуу үед буюу XVII-XVIII зуунд, харьцангуй хязгаарлагдмал хүрээнд буюу Бүддийн шашны холбогдолтой ном зохиолын орчуулгын хүрээнд буй болсон Сонгодог монгол бичгийн хэлийг гол (хэмжүүр) болгон авч үзээд түүнээс эрт нэгэнт бүрэлдэн буй болчихсон бөгөөд Сонгодог монгол бичгийн хэлний зэргэцээ байсаар ирсэн төдийгүй бидний үе хүртэл үргэлжилсээр

² Ц. Шагдарсүрэн, *Монгол хэлний хөгжлийн эртний үе, түүнийг судласан тойм*, - Эртний монгол хэлний судлал (Монголын судлалын сонгомол өгүүлэлийн эрхи, I хэлмэли: Монгол хэл бичиг, II дэвтэр), Улаанбаатар, 1999, (67 - 125) 78 - 85 -р талаас үзмүү.

³ Б. Ринчен, *Монгол бичгийн хэлний зүй*, I - IV боть, Улаанбаатар, 1964 - 1968; Ц. Шагдарсүрэн, *Монгол үсэг зүй, тэргүүн дэвтэр*, Улаанбаатар, 1981, 13-р тал; Б. Я. Владимирцов, *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия*, Введение и фонетика, Ленинград, 1929, стр. 23 - 24.

⁴ Micheal Weiers, *Untersuchungen zu einer Historischen Grammatik des Praklassischen Schriftmongolisch*, Wiesbaden, 1969; Kaare Grønbech, J. R. Krueger, *An introduction to Classical (Literary) Mongolian*, Wiesbaden, 1955; Stanislaw Kaluzyński, *Klasyczny język mongolski* (Seria: Języki Azji i Afryki), Warszawa, 1998.

буй ер иргэнлиг чанартай монгол бичгийн хэлийг хавсарга мэт үзсэн байдал харагдана. Хоёрт, монгол бичгийн хэлийг тийнхүү хоёр үед хуваан үзэх бөгөөс дээр өгүүлсэнчлэн шашин номын зохиолоос гаднахи өдгөө хүртэл монгол бичгээр хэрэглэгдсээр байгаа төр-иргэнлиг чанартай ном зохиолын хэл нь монгол бичгийн хэлний үечлэлд хамаарахгүй болоход хүрдэг. Тэгээд ч академич Б. Ринчен нарын зэрэг манай ахмад үеийн эрдэмтэд *Монгол бичгийн хэл* гэдэг нийтлэг ерөнхий нэр томъёог хэрэглэхийн сац Сонгодог монгол бичгийн хэлний үеийн онцлогийн тухайд *Номын хэл* буюу *Сударын хэл* (заримдаа сударын орчуулга) хэмээх уламжлалт нэр томъёог хэрэглэсэн байдаг нь ч үүнтэй холбоотой буй заа⁵. Бас зарим судлагч Сонгодог монгол бичгийн хэл гэдгийг бичгийн хэлний үечлэлд хамаагүй мэтээр ойлгож болох боловч монгол бичгийн хэлний хөгжлийн ерөнхий байдлыг түүхэчлэн авч үзэх бөгөөс Сонгодог монгол бичгийн хэл нь үгсийн сан, хэл найруулга, нэр томъёо, үргэлжилсэн хугацаа болон Бүддийн ёсны их бага таван ухааныг бүхэлд нь хамарсан зэргээрээ Монгол бичгийн хэлнийхиэс ялгарах бие даасан нэгэн үеийг төлөөлөн чадахуйц онцлогтой гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй юм. Гэхдээ Сонгодог монгол бичгийн хэлний үед дээр цагаас уламжласаар ирсэн монгол бичгийн хэл нь улс төрийн хүрээ болон төр-иргэний утгазохиол, түүнчилэн хятад манжаас орчуулсан утгазохиолын хүрээнд зэргэд хөгжсөөр ирсэн бөлгөө. Энэ тухай нэлээд эртнээс нэрт монголч Б. Я. Владимирцов, нангиадач В. Алексеев, академич Ринчен, профессор Д. Кара (G. Kara) нарын ажин тэмдэглэсэн зүйл буй⁶.

Энэ бүхэнд үндэслэж, Монгол бичгийн хэлний хөгжилийн үечлэлийг эргэн нягтлах шалтгаан буй бөгөөд үүний сац Сонгодог монгол бичгийн хэлний зэргэцээ уугуул монгол бичгийн хэл ч уламжлалынхаа зүй тогтолоор зэргэд хөгжсөөр байсан гэдгийг бодолцохгүй байхын аргагүй. Харин тийнхүү үечлэхдээ хэлний хөгжлийн бодот байдал болон цаг хугацааны үүднээс хэрхэн зөв тогтоох вэ? гэдэг дээр холбогдох баримт хэрэглэгдэхүүний хувьд илүү өргөн, хэлшинжлэлийн судлагдахууны тухайд илүү нарийвчласан судлагаа эрхгүй шаардагдах бөгөөд бас нэгэн эзнээ хүлээж буй чухал сэдэв мөнөөс мөн бөлгөө.

Тэр бүхнийг үл нуршин өгүүлэх нь, толилуулан буй энэ өгүүлэлд Сонгодог монгол бичгийн хэл хэмээх судлагдахууны зарим нэгэн онцлогийн талаар дурдахыг зорьсон болно. Эхлээд сонгодог монгол бичгийн хэл гэдгийг хэрхэн тодорхойлсон байдлыг авч үзсүү.

Академич Б. Я. Владимирцов Монгол бичгийн хэлийг гурван үе болгон хувааж хоёрдугаар үе нь ХIY зууны эхин үеэс эхлэнэ хэмээгээд түүнийгээ тодорхойлохдоо энэ үеэс "монгол бичгийн хэл нь төвөд, уйгурын номтой номтой лам нарын удирдалгаар Бүддийн зохиол

⁵ Б. Ринчен, *Бичгийн хэл*, - Шинжлэх ухаан амьдрал, 1966, No. 2, Улаанбаатар, 18 - 22.

⁶ В. Я. Владимирцов, *Монгольская литература*, - Сборник статей, Вып. второй, Петербург, 1920, стр. 3; В. А. Алексеев, *Китайская литература*, - Сборник статей, Вып. второй, Петербург, 1920, стр. 17; Б. Ринчен, *К истории перевода в Монголии*, - Мастерство перевода 1971, Сборник восьмой, Москва, 1971, стр. 376. Б. Л. Рифтин, В. И. Семанов, *Монгольские переводы старинных китайских романов и повестей*, - Литературные связи Монголии, Москва, 1981, стр. 272; Д. Кара, *Книги монгольских кочевников*, Москва, 1972, стр. 70.

бүтээлийг орчуулахад хэрэглэгдэж эхлэжээ" гэж 1929 онд бичээд энэ үед монгол бичгийн хэл бүрэн хэлбэржиж, тухайн үеийн амьд аялгуунуудын нөлөөгөөр буй болсон шинэ байдлаар бүрэлдэн төлөвшиж, мөн зөв бичихзүй тогтсон гэж үзжээ. Цааш нь үечлэхдээ монгол бичгийн хэлний хөгжлийн гутгаар үе нь Монголд соёл боловсрол хийгээд Бүддизм сэргэсний үр дагавар болж XVI зууны эцэс, XVII зууны эхин үеэс эхлэсэн бөгөөд ардын амьд аялгууны нөлөөгөөр зөв бичихзүйн хувьд бүрнээ төлөвшиж, хэлбэр судлалын хувьд хуучирсан зүйлийг авах гээхийн ёсоор зөв шийдэж чадсан учир энэ үеийг "Сонгодог" бичгийн хэл гэж нэрлэж болох бөлгөө. Энэхүү "сонгодог" монгол бичгийн хэл нь монголчуудын хувьд нийт бичиг зохиолын хэл болж одоо хүртэл оршсоор ажээ⁷ гэж тэмдэглэжээ.

Монгол бичгийн хэлний хөгжлийн хоёр, гуравдугаар үеийн мөн чанарын тухай дээр эшлэн авсан тодорхойлолт нь бидний хувьд хамгийн чухал зүйл мөн боловч энэ ташрамд нэмэн тэмдэглэхэд, чухам энэ үед монгол бичгийн хэл бүрэн хэлбэржин шинэ маягаар бүрэлдэн төлөвшиж, ардын амьд аялгууны нөлөөгөөр зөв бичихзүй нь бүрнээ тогтсон гэх буюу Сонгодог монгол бичгийн хэл нь өдгөө хүртэл нийт бичиг зохиолын хэлний үүргээр хэрэглэгдсээр байна гэх зэрэг бусад дүгнэлтийн тухайд бодолцох зүйл бас бий. Энэ талаар хойно арай дэлгэрүүлэн өгүүлэх болно. Үүний учир гэвэл Б. Я. Владимирцовын алдарт "Хэлний зүй" хэвлэгдсэнээс хойшхи 70 гаруй жилийн туршид шинээр олдсон монгол бичгийн баримт хэрэглэгдэхүүн хийгээд судлагааны дүгнэлт зэргээс үүдэж өнөөдрийн төвшинд дээрхи бүх дүгнэлтийг хөдөлгөөнгүй үнэн гэж үзэхэд учир дутагдалтай. Зөвхөн энэ асуудлын хувьд ч биш, бусад олон судлагааны дүгнэлт цаг хугацааны саалтад өөрчлөгдөх явдал цөөнгүй байдаг бөгөөд академич Б. Я. Владимирцовын "Хэлний зүй" хэвлэгдсэнээс хойш 45 жилийн дараа яг ийм сэдвээр уг бүтээлд зориулан Н. Поппе профессор тусхайлан нэгэн өгүүлэл бичсэнийг энэ далимаар өгүүлэхэд илүүц болохгүй буй заа⁸.

Профессор Н. Поппе монгол бичгийн хэлний хөгжлийг мөн л Сонгодог монгол бичгийн хэлний өмнөхи үе, Сонгодог монгол бичгийн хэлний үе, орчин цагийн монгол бичгийн хэл хэмээн гурав хуваан үзээд Сонгодог монгол бичгийн хэлний үүслийг Монгол газар Бүддийн шашин эрчимтэй дэлгэрсэнтэй холбож төвөд, самгард гаралтай Бүддийн гүн ухаан, шашны нэр томъёогоор монгол бичгийн хэл баяжсан гэдэг онцлогийн хажуугаар зөв бичихзүй нэгэн мөр болж бичгийн хэлнээ ярианы өнгө аяс нөлөөлж, улмаар нийлэмж зохимжгүй бүх зүйл арилсан учир бидний Сонгодог хэмээх шинэ хэл буй болсон гэж дурдсан нь буй⁹. Өөр нэг бүтээлдээ "XVII-XVIII зууны модон барын ном зохиолын хэлийг Сонгодог монгол (бичгийн) хэл хэмээмүй" гэж тодорхойлжээ¹⁰. Тэгэхдээ Сонгодог монгол бичгийн хэл нь бүх ном бичгийн хувьд ноёрхож чадаагүй, зөвхөн Бүддийн шашны чанартай модон барын хэвлэлд л

⁷ Б. Я. Владимирцов, *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия*, Введение и фонетика, Ленинград, 1929, стр. 19 - 25.

⁸ Nicholas Poppe, *Vladimirtsov's grammar Forty-five years later*, - *Mongolian Studies*, Vol. 2 (1975), pp. 115 - 131.

⁹ N. Poppe, *Grammar of Written Mongolian*, Wiesbaden, 1964, p. 3.

¹⁰ N. Poppe, *Introduction to Altaic Linguistics*, Wiesbaden, 1965, p. 17.

хэрэглэгдэж байсан бөгөөд иргэний ном зохиолд нутаг нутгийн аялгуу нөлөөлдөг нь үргэлжлэсээр байсан юм гэдгийг ажиглан тэмдэглэсэнээрээ¹¹ Б. Я. Владирмирцовынхиос ялгардаг бөлгөө.

Тэгвэл Сонгодог монгол (бичгийн) хэлний талаар Кааре Грөнбех (Kaare Grønbech), Ж. Крюгер (John R. Krueger) нар гол судлагдахуун болгож бичсэн "Сонгодог монгол (судар номын) хэлний удиртхал"-даа хэрхэн тодорхойлсныг авч үзье. Түүнд бичсэнээр, XIII зууны эхин үед буюу Чингис хааны зарлигаар Уйгураас босоо бичиг авсанаар анх бичигтэй болсон; Эртний монгол хэл нь XII-XIII зууны монгол хэл байсан бөгөөд 1224 онд бичсэн зүйлд олон талаараа эртний дуудалгыг тусгасан байдаг гээд цааш нь Сонгодог монгол хэл нь Монголын Лигдэн хаан (1604-1634)-ы хүчин зүтгэлээр Төвөдийн бурханы шашны хөлгөн судар "Ганжуур"-ыг орчуулагчдын буй болгосон судар номын хэл бөгөөд 1720 онд Бээжинд хянан зассан модон барын хэвлэлийн дагуу эцсийн байдлаар төлөвшин тогтож тэр хэвээрээ өдгөөгийн судар номын (хэлний) хэм хэмжээ болсоор ирсэн юм хэмээн тодорхойлжээ¹².

Энэ бүхнээс үзэхэд монгол бичиг болон Монгол бичгийн хэлний хөгжлийн эхийг нэг бол Тататунгаагийн, эсбөгөөс Сажа газарын Гунгаажалцаны домогтой холбож XIII зууны эхин үед холбогдуулсан байх ба Сонгодог монгол бичгийн хэлний үүслийг XVII зууны Бүддийн хөлгөн сударын орчуулгын хэлтэй холбон үзэж улмаар Б. Я. Владимирцов, Кааре Грөнбех (Kaare Grønbech) нарын зохиолд өдгөө хүртэл судар номын хэлний үүргээр үргэлжлэсээр байна хэмээн үзсэн байдал бэлхэнээ харагдах бөлгөө.

Профессор Д. Кара сонгодог (бичгийн) хэл гэдэг нэр томъёо нь XVII зууны модон барын ном зохиолын хэл юм хэмээн тэмдэглэжээ. XVI-XVII зуунд бичгийн хэл нь зөв бичихзүйн хувьд мэдэгдэхүйц хувирлыг үзэж улмаар үгийн сан болон хэлний зүйд нөлөөлсөнийг дурдаад энэхүү хоёр зуун жилийг шилжилтийн үе хэмээн үзчүхүй¹³.

Академич Д. Төмөртоого "монгол бичгийн хэл нь бичилгийн дүрэм, хэлний зүй, үгсийн сан, хэл найруулгынхаа талаар улам бүр боловсорсоор жинхэнэ сонгодог бичгийн хэл болжээ; ... сонгодог бичгийн хэлний онцлогийн тухайд гэвэл, тэр нь авиа зүй, үг зүйн шинжээрээ өмнөхи үе шатныхаа нэгэн адил эртний монгол хэлний сүүлч үеийн байдлыг тусгах бөгөөд харин үгсийн сангийн бүрэлдэхүүн, хэл найруулгын төрөл зүйлээрээ ихээхэн шинэчилэгджээ ..." гэж тэмдэглэсэн байх ба үечлэлийн тухайд хэлний хөгжлийн ерөнхий төвшинг цуваа цагийн үүднээс авч үзээд "...одоогийн бичгийн хэл нь монгол бичгийн хэлний түүхийн хоёрдугаар үе буюу сонгодог бичгийн хэлний үед шууд хамаарна..." гэжээ¹⁴.

¹¹ N. Poppe, *Grammar of Written Mongolian*, Wiesbaden, 1964, p. 3.

¹² Kaare Grønbech, J. R. Krueger, *An introduction to Classical (Literary) Mongolian*, Wiesbaden, 1955, p. 13.

¹³ Д. Кара, *Книги монгольских кочевников*, Москва, 1972, стр. 69.

¹⁴ Д. Төмөртоого, *Монгол хэлний түүхэн хэл зүй*, 1: Түүхэн авиа зүй, Улаанбаатар, 1992, 46-47-р тап.

Судлагдахуунаа улам тодруулахын үүднээс харьцангуй хожуу буюу XVII- XVIII зуунд буй болсон Сонгодог монгол бичигийн хэл нь цаг хугацааны хувьд үлэмжхэн түрүү үе буюу эртний монгол хэлнээ хамаарах Монгол бичигийн хэлнээс чухам ямар ялгаатай, хэл найруулгын ямар ямар өвөрмиц онцлогтой болохыг холбогдох хэрэглэгдэхүүнүүдтэй зэргэцүүлэн зарим баримт жишээ татан үзэцгээе.

1. "Монголын нууц товчоон", "Алтан товч" хоёрын зэргэд бичвэрийг харьцуулан үзэхэд найруулгын ялгаа, тэр дундаа монгол хэлний өгүүлбэрийн гишүүдийн байрын хувьд нэлээд өвөрмиц ялгаа харагдана.

(MHT: § 30, 819-820)¹⁵

Buqu-qatagi aqa-inu
Bodoncar-mungqaq de'ü-yü'en ene
Onan müren huru'u odula'a ke'en
erin irejü ...

(ATo: 7a-7b, 208-210)¹⁶

Tedüi atala Buqu-qatagi aq-
a-inü: degüü-minü Bodančar ene
mören uruyu oduluy-a: esen-ü
ükübeü kemen odbasu...

(MHT: § 32, 830-832)¹⁷

Buqu-qatagi aqa-inu üje'et
taniju abu'at uduricu Onan mören
ö'ede qataraju yorciju talbiba.

(ATo: 7b, 219-221)¹⁸

Aq-a-inü Buqu-qatagi degüü-yügen
Bodančar-i üjeged taniju abuyad ülü
ögüleidün qarin qataribasü:...

(MHT: § 54, 1119-1120)¹⁹

[Yisügei ba'atur] ...ger-tür-iyen qarin
ha'ulju Nekün-taisi aqa-yu'an Dāritai-
otcigin de'ü-ben udurtcu irejü'üi...

(ATo: 10b, 317-318)²⁰

[Yisügei bayatur] ...ger-tür-iyen
qariju: aq-a-yuyan Nekün tayisi-yi:
degüü yuyan Daridai Odčiqin-l
uduridču kürküi-lüge...

¹⁵ Igor de Rachewiltz, *Index to the Secret History of the Mongols*, Bloomington, 1972, p. 18.

¹⁶ *Altan tobčā*, Ulayanbayatur, 1990; Hans-Peter Vietze, Gendeng Lubsang, *Altan tobčā*, Tokyo, 1992, p. 5.

¹⁷ Igor de Rachewiltz, *Index to the Secret History of the Mongols*, Bloomington, 1972, p. 18.

¹⁸ *Altan tobčā*, Ulayanbayatur, 1990; Hans-Peter Vietze, Gendeng Lubsang, *Altan tobčā*, Tokyo, 1992, p. 5.

¹⁹ Igor de Rachewiltz, *Index to the Secret History of the Mongols*, Bloomington, 1972, p. 22.

²⁰ *Altan tobčā*, Ulayanbayatur, 1990; Hans-Peter Vietze, Gendeng Lubsang, *Altan tobčā*, Tokyo, 1992, p. 8.

(МНТ: § 56, 1134-1201)²¹

... hö'elün-üjin-i Yisügei-ba'atur delbege-dece kötöljü Nekün-taisi aqa-inu uduritcu Dāritai-otcigin de'ü-inü kilijü dergecejü ayisuqui-tur...

(АТо: 11а, 333-334)²²

... Ögelen Üčin-ü delbege-eče bariju aq-a-inu Nekün tayisi uduridču degüü-inü Daridai Odčin temegen gelijü ayisuqui-tur...

Энэ мэтээр "Алтан товч"-ийн эхэд гол төлөв хамаатуулах нөхцөл бүхий тохиолдолд оноосон нэрийн байрыг ураг төрлийн нэрийн хойно нь сольж оруулдаг ёсон тогтолцоотой байсныг харж болно. Дээр бид хагас заримаас нь жишээ татсан болно.

Үүнээс гадна "Алтан товч"-ийн дотор "Монголын нууц товчоон"-той тохирч буй бичвэрт тодотгол үгийг нэмэхдээ тодотгуулагчийн ард оруулсан баримт нэг бус байгааг дараахи хоёр жишээгээр харуулж болно.

(МНТ: § 90, 2006-2007)²³

...sirqa aqta-tan-i de'erme a{b}cu otba kē'esü Belgütei ügülerün...

(АТо: 21а, 652)²⁴

...siry-a ayta biden-i [(?)=biden-ü^{Ts. Sh}] degerm-e abču odba kemebesü: Belgüdei ögülerün...

(МНТ: § 154, 4719-4720)²⁵

...erde üdür-ece Tatar irgen ebüges eciges-i baraqsan бүлө'e[:]

(АТо: 55а, 1721)²⁶

...Erte edür-eče Tatar irgen ečiges ebüges-i biden-ü baraysan bölüge:

Яг ийм найруулгын баримт "Алтан товч"-ийн дотор нэлээд хэвшсэн байдалтай бараг тогтолцоотой байжээ гэж үзэж болохуйцаар тохиолдож байна. Тухайлбал: "Монголын нууц товчоон"-ы § 149-тэй дүйх хэсэгт:

(АТо: 52а, 1633-1634)²⁷

Sirgetü ebügen ečige biden-ü ükügülbesü

²¹ Igor de Rachewiltz, *Index to the Secret History of the Mongols*, Bloomington, 1972, p. 23.

²² *Altan tobč*, Ulaγanbayatur, 1990; Hans-Peter Vietze, Gendeng Lubsang, *Altan tobč*, Tokyo, 1992, p. 8.

²³ Igor de Rachewiltz, *Index to the Secret History of the Mongols*, Bloomington, 1972, p. 34.

²⁴ *Altan tobč*, Ulaγanbayatur, 1990; Hans-Peter Vietze, Gendeng Lubsang, *Altan tobč*, Tokyo, 1992, p. 15.

²⁵ Igor de Rachewiltz, *Index to the Secret History of the Mongols*, Bloomington, 1972, p. 72.

²⁶ *Altan tobč*, Ulaγanbayatur, 1990; Hans-Peter Vietze, Gendeng Lubsang, *Altan tobč*, Tokyo, 1992, p. 39.

²⁷ *Altan tobč*, Ulaγanbayatur, 1990, 52.a; Hans-Peter Vietze, Gendeng Lubsang, *Altan tobč*, Tokyo, 1992, p. 37.

гэсэн хэсэг байгаа нь нь үүний батлагаа болж өгнө.

2. Тэгвэл цаг хугацааны хувьд "Алтан товч"-той ойролцоо нэг үед зохиогдсон сонгодог монгол бичгийн хэлний бусад дурсгалуудад ямар байна вэ? гэдэгийг анхааралгүй орхиж болохгүй бөгөөд үүнээс өмнө зохиогч энэ талаар тэмдэглэж байсан зүйл буй билээ²⁸.

Найруулгын хувьд дээрхи лүгээ адил баримт "Хураангуй алтан товч" (Qu. A. To.), "Шар тууж" (Si. Tu.) , "Асрагч нэртийн түүх" (ANT)- нээ цөөн бус тохиолдож байна.

(Qu. A. To: 10) ²⁹	<u>Aq-a-dayan Bigter-tü kelerün ...</u>
(Qu. A. To: 12) ³⁰	"Гаяҗа <u>köbegün-iyen Temüjin-i</u> Olqunud-tu kürger-e odumui"
(Si. Tu: 58 - 59) ³¹	Elbeg qayan <u>deqüü-ben Qarayčuy</u> <u>dügüreng tayiji-yi</u> alaju ...
(Si. Tu: 63) ³²	<u>Köbegün-iyen Esen-i</u> iregülijü ...
(Si. Tu: 102) ³³	<u>Ökin-inü Bayıqan-jula-ača</u> dalai blam-a rGyamco qubilaysan ...
(ANT: 16) ³⁴	<u>Ečige-yin minü Naqu bayan-u</u> jögegsen, gayča köbegün nadur mundasi-ügei biy [=bui ^{Ts. Sh}]
(ANT: 26) ³⁵	Senggüm <u>ečige-dür-iyen Ong qayan-</u> <u>dur morday-a</u> geju ilegebe.
(ANT: 52) ³⁶	<u>Köbegün minü Toyan-i</u> Kümün-dür yakin jaruyulunam.

²⁸ Ц. Шагдарсүрэн, *Монгол хэлний хөгжлийн эртний үе, түүнийг судласан тойм*, - Эртний монгол хэлний судлал (Монголын судлалын сонгомол өгүүлэлийн эрхи, I хэлмэли: Монгол хэл бичиг, II дэвтэр), Улаанбаатар, 1999, (67 - 125) 82 - 84 -р талаас үзмүү.

²⁹ (Liü Jin-süve,) *Qad-un ündüsün-ü quriyangxui Altan tobč*, Kökeqota, 1999, 10.

³⁰ (Liü Jin-süve,) *Qad-un ündüsün-ü quriyangxui Altan tobč*, Kökeqota, 1999, 12.

³¹ (Н. П. Шастина,) *Шара туджи - Монгольская летопись XVII века*, Москва-Ленинград, 1957, 58-59.

³² (Н. П. Шастина,) *Шара туджи - Монгольская летопись XVII века*, Москва-Ленинград, 1957, 63.

³³ (Н. П. Шастина,) *Шара туджи - Монгольская летопись XVII века*, Москва-Ленинград, 1957, 102.

³⁴ *Vyamba, Asaraγā neretü-yin teüke*, Улаанбаатар, 1960, 16.

³⁵ *Vyamba, Asaraγā neretü-yin teüke*, Улаанбаатар, 1960, 26.

³⁶ *Vyamba, Asaraγā neretü-yin teüke*, Улаанбаатар, 1960, 52.

Монгол бичгийн хэлтэй харьцуулахад хэл найруулгын хувьд өвөрмиц ялгаатай гэж дээр бидний эшлэл авсан түүхийн сурвалжууд цөмөөрөө XVII зууны монгол түүхчидийн бүтээл болно. Цаг хугацааны хувьд эдгээрийн дараа XVIII зуунд мөн л монгол хэлээр Молом Ранбжамба Данзандагвын зохиосон "Зүрхэний толтын тайлбар үсгийн эндүүрлийн харанхуйг арилгагч огторгуйн маани хэмээх оршивай" хэмээх, сэдвийн хувьд цэвэр хэлшинжлэлийн салбарт багтах бүтээлд монгол бичгийн хэлний тогтсон найруулгыг зөрчсөн баримт нэг бус тохиолдож байгааг үүнээс өмнө тэмдэглэж байсан билээ³⁷. Үүнд:

... тэдгээр үсгийг дуудахуйд ... гэхийг	... <u>үсэг тэдгээрийг</u> дуудахуйд...
... аминаас хагацах	... <u>амин-лугаа</u> хагацах...

гэх зэрэг олон жишээг хэлж болно.

Энэ мэтээр тодотгогчийг тодотгуулагчийн дараа байрлуулсан нь төвөд хэлний найруулгын нөлөө, хоёрдугаар жишээнд ... аминаас хагацах гэхийг ...амин-лугаа хагацах... гэсэн нь төвөд хэлний "хураах үг"-ийн махчилсан орчуулгаас үүдсэн гэж үзэх бүрэн үндэс байна. Энэ мэтээр "сонгодог монгол хэл" хэмээх "сударын хэл"-нээ монгол найруулгаар:

... арван дүндүүр нь тэрбүм...	гэхийг	... <u>дүндүүр арав нь тэрбүм</u> ...
... улаан өнгө...	гэхийг	... <u>өнгө улаан</u> ...
... их уул...	гэхийг	... <u>уул их</u> ...

гэх зэргээр найруулаад хэвшил болчихсон жишээ захаас аван дайралддаг.

Дээр өгүүлсэнчилэн тодотголыг тодотгуулагчийнхи нь ард байрлуулсан баримт "Панчатантра"-гийн монгол эхэд:

"... γadanaki ünēsün juuq-a-u dotura talbiju..."

(угтаа "γadanaki juuq-a-yin ünēsün(-ü) dotura talbiju"^{Ts. Sh}),

гэж байгааг солонгосын залуу монголч Чой Хён-вон (Hyong-won Choi) ажиглан тэмдэглэсэн³⁸ нь найруулгын хувьд монгол хэлний зүй тогтолоос их өөр байдал гадны судлагчийн тухайд тодорхой мэдрэгдсэний нутлагаа буй заа.

Үүнээс гадна төвөдөөс монголчилсон бүтээлийн дотор, монгол хэлний зүй болон найруулах ёсыг илэрхий гажуудуулж, Энэдхэг-Европ хэлний өгүүлбэр зүйг эрхгүй санагдуулам бүтэц найруулга олонтаа тохиолддог билээ. Жишээ нь:

³⁷ Ц. Шагдарсүрэн, *Монгол хэлний хөгжлийн эртний үе, түүнийг судласан тойм*, - Эртний монгол хэлний судлал (Монголын судлалын сонгомол өгүүлэлийн эрхи, I хэлмэли: Монгол хэл бичиг, II дэвтэр), Улаанбаатар, 1999, (67 - 125) 83.

³⁸ Hyong-won Choi, *Dissertation zur Erlangung des philosophischen Doktorgrades am Fachbereich Historisch Wissenschaften der Georg-August-Universität zu Göttingen*, Göttingen, 1996, pp. 7, 43.

... Ганц миний тул та бүгд маш ихэд зовогдох...

..."Ай охин минь, чи энэ өдөрөөс хойногшид нас турхаруу сайн дээл өмсөөд, сайн амтат идээн идэгдэхүй. Өдөр бүр тасрал үгүй толиндоо үзэгдэхүй" хэмээн сургасанд охин-бар "тийн хийсүгэй" хэмээн өгүүлсэнд...

... Өөрийн нөхөд сэлт бүгдээр, Шири Тигба нэрт улс хамигаа бүхий тэнд одбай...

... Яван үйлэд! / ... Суун үйлэд!

... Хором нэгэн болоод...

гэх мэт болно³⁹. Үүнд, эхний хоёр өгүүлбэрт монгол хэлний үүднээс огт шаардалгагүй үйлдэгдэх хэвийг хэрэглэжээ. Гуравдугаар өгүүлбэрт, тухайлсан газар орон болоод тодорхой зүгийг заахдаа (орос хэлээр ...там, где..., англиар ...where; where there...; the place where...; францаар ...la, ou...; [a] l'endroit, ou... гэх мэтээр) Энэдхэг-Европ хэлнээ холбодог шиг хэлзүйн найруулгын бүтэц харагдаж байна. Үүний уг учрыг нягтлавал энэ нь төвөд хэлний тогтсон хэлэлгийн үгчилсэн орчуулга бөлгөө. (Энэ жишээнд холбогдох өөр баримтыг хойно дахин ярина). Дөрөв, тавдугаар жишээнд монголоор *Яв! Суу!* гэж ганц ганц үгээр хэлж болдог санааг төвөд хэлний зүйд нийцүүлэн хошоод үгээр буулгажээ. Зургадугаар жишээнд монголоор ...нэгэн хором болоод... гэсэн санааг төвөд хэлний найруулгын бүтэц, байрыг махачилан буулгасан байдал илэрхий харагдаж байна.

Шашины агуулга бүхий орчуулгын зохиол бүтээлийн найруулга дахи дээрхи маягийн "төвөдчилсэн" нөлөө монголын олон нутагт, янз бүрийн үед төвөдөөс монголчилосон сударын бараг бүх зохиолд баримтлах "зарчим" болж уламжлагдсан гэж үзэх баримт захаас аван дайралддаг. Энэ нь бурхан шашины номыг орчуулахад уг эхэд нь байгаа хэлзүйн хэлбэр, найруулсан байдал, үгийн тоог өөрчлөж болохгүй гэдэг тогтсон үзэлтэй шууд холбоотой бөлгөө. Монголчуудын дунд "Очироор огтлогч", Таслагч очир" гэх зэрэг хэдэн нэрээр өргөн тархсан "*Vajrachedikā*" гэдэг сударын хоёр орчуулгаас дээр эшлэл болгосон нэг жишээг улам тодруулах зорилгоор холбогдох хэсгээр жишээ татаж харьцуулан үзсүү.

...Tendeče olan ayay-a tegimlig-üd llaju tegüs nögčigsen qamiy-a bükü tende jorčiyad odču.⁴⁰

... llaju tegüs nögčigsen qamiy-a bükü tere жүг-түр bökey(i)n alayaban qamtudqaju бүр-үн.⁴¹

³⁹ Kaare Grønbech, J. R. Krueger, *An introduction to Classical (Literary) Mongolian*, Wiesbaden, 1955, pp. 49, 55.

⁴⁰ Sarkozi Alica, *Preklasszikus Emlékek*, 4, Budapest, 1969, 8.

⁴¹ Sarkozi Alica, *Preklasszikus Emlékek*, 4, Budapest, 1969, 9.

Сонгодог монгол бичигийн хэлний өмнөхи үеийн орчуулга дахи энэ хоёр хэсгийг Ойродын Зая Бандид Намхайжамцо (1599-1662) XVII зуунд хэрхэн монголчилсныг тод гар бичмэл судартай нь харьцуулбал дараахи мэт байна.

...Tende olon dge-slong llayun tögüsüqsen xamiyā bui tende odöd.⁴²

...llayun tögüsüqsen xamiyā aqsan tere jüg aliyabēn хамтудхaji sögüdүн...⁴³

Үүнийг төвөд эхтэй нь тулгаж үзвэл монгол сударын хэлний ...qamiγ-a бүкү tende..., ...qamiγ-a бүкү tere jüg-tür...; тод бичигийн хэлний ...xamiyā bui tende..., ...xamiyā aqsan tere jüg... гэдэг хошоод хэлэлгэ нь уг төвөд эхийн ࠠᠭᠠᠯᠠᠪᠠᠳᠦᠷ (ga la ba der) гэсэн үгтэй яг үгчилэн тохирч байна (Төвөд эхийн холбогдох хэсгийг хавсралтаас үзнэ үү?).

Дээрхи эшлэл жишээ болон сударын хэлний бусад баримтаас үзэхэд, XIII- XIV зууны үед бурханы шашины ном зохиолыг төвөдөөс монголчлоход баримтлаж байсан зарчим XVII зууны эрчимтэй орчуулгын үед бүр уламжлал болж тэр үеийн монгол ном сударын хэлнээ төвөд хэлний зүй болон найруулгын нөлөө улам их тусах болсон нь бэлхэнээ харагдах бөгөөд энэ тухай Кааре Грөнбех (Kaare Grønbech), Ж. Крюгер (John R. Krueger), академич Ринчен, профессор Д. Кара (G. Kara) зэрэг олон эрдэмтэн нэг бус удаа тусхайлан тэмдэглэсэн зүйл буй бөлгөө⁴⁴.

Бас нэгэн зүйл: Монгол газар Бурханы шашин гуравдахи удаагаа хүчтэй дэлгэрсэн үеэс төвөд хэл зөвхөн монгол бичгийн хэлэнд нөлөөлөөд зогссонгүй, монголын түүх бичилгэ, үлгэр домог хийгээд яруу найрагийн уламжлалд эртний энэдхэг болон төвөдийн нөлөө үлэмжхэн тусахын үүд хаалгыг нээсэн гэж хэлж болно. Энэ тухай Б. Я. Владимирцов бүр 1921 онд

"...Бүддизмтэй хамт Монголд нэвтэрч ирсэн Энэдхэг гаралтай үлгэр домог нь монгол үндэсний үлгэрийг бараг бүрнээ үстгаж, түүнийг ар тийш нь шахсаар хутгалджээ..."⁴⁵

⁴² *Xutuqtu biligiin ānadu kūrūqsen tasuluqā oār kemākū yeke kölgöni sudur orošbo*, (Зохиогчийн цуглуулгад буй тод гар бичмэл), 2a.

⁴³ *Xutuqtu biligiin ānadu kūrūqsen tasuluqā oār kemākū yeke kölgöni sudur orošbo*, (Зохиогчийн цуглуулгад буй тод гар бичмэл), 2b.

⁴⁴ Kaare Grønbech, J. R. Krueger, *An introduction to Classical (Literary) Mongolian*, Wiesbaden, 1955, p. 35; Б. Ринчен, *К истории перевода в Монголии*, - Мастерство перевода 1971, Сборник восьмой, Москва, 1971, стр. 376; Д. Кара, *Книги монгольских кочевников*, Москва, 1972, стр. 70.

⁴⁵ Б. Я. Владимирцов, *Монгольский сборник рассказов из Райцантра*, Петербург, 1921, стр. 36.

гэж бичсэн нь өдгөө анзаарах ёстой нэгэн асуудал. Үүнчилэн, Дандины "Зохист аялгуун" хэмээх эртний энэдхэгийн яруу найрагийн (чухамдаа зөвхөн яруу найраг төдийгүй ер зохиох туурвих) онол монгол газар нэвтэрч, монголын олон үеийн зохист аялгууч нар уг онолыг нарийсган хөгжүүлэхэд үлэмжхэн анхаарсаар ирсэн нь нэгэн талаас соёлын харилцааны хувьд яриангүй дэвшил мөн боловч нөгөө талаас үзвэл, уугуул монгол яруу найраг, зохиох туурвих уламжлалыг нарийсган хөгжүүлэхэд анхаарал сарниулах хүчин зүйл болсоныг бас үгүйсгэх аргагүй гэж боддогоо үүний өмнө нэгэнтээ цухас дурдаж байсан билээ⁴⁶.

Гэхдээ түүхийн үлэмжхэн ээдрээ эгзэгтэй цагт, тэр үеийн Монголын удирдагч нарын ухаалаг бодолгын дүнд, улс орон алгасуулан алс холын энэдхэг, төвөдийн соёлын нөлөөг хүртсэн нь тухайн үеийн Монголын улс төр, тусгаар тогтнолын хувьд хамгийн аюулгүй, харин ч монголчуудыг нэг шашины дор нэгтгэх боломжийг олгосон гэдгийг бас үгүйсгэх аргагүй буй заа. Магадгүй тухайн үедээ энэ нь ч илүү эрхэм байсан байж болох юм.

Ташрамдуулан дурдсан энэ бүхнийг үл өгүүлэн гол судлагдахуун болох "сонгодог монгол бичигийн хэл"-ний тухайд ямар дүгнэлт гарч болох вэ? гэдэг асуултад дээр дурдсан баримт сэлтдээ тулгуурлан товч хариулахыг оролдоё.

1. Монгол бичигийн хэлний хөгжлийн явцад XVII зуунаас бүрэнээ бүрэлдэн тогтсон сонгодог монгол бичигийн хэл хэмээх монгол сударын хэл нь шашин сурталын хүрээнд тухайн үеийнхээ нийгмийн хэрэгцээг тэгш хангаж монгол хэлээр Бүддийн их бага таван ухааны бүхий л бүтээлийг орчуулах, зохион туурвих нөхцөлийг буй болгосноороо "сонгодог монгол бичигийн хэл"-ний төвшинд хүрч улс төрийн бус хүрээнд гүнзгий ул мөрөө үлдээсэн гэж үзэх бүрэн үндэстэй. Харин шашин сурталын бус хүрээнд тухайлбал: төр ёсны албан бичиг баримт, улс төр-иргэнлиг уран зохиол, мөн түүнчилэн хятад болон манжаас орчуулсан зохиол бүтээлийн тухайд монгол бичигийн хэл өөрийнхөө зүй тогтлоор үргэлжлэн зэргэд хэрэглэгдсээр ирсэн гэдэгийг мартаж аргагүй юм.

2. "Сонгодог монгол бичигийн хэл" нь найруулгазүйн хувьд төвөд хэлний зүйн нөлөөг үлэмжхэн хүлээн авч хэвшүүлсэнээрээ монгол хэлний зүйн уугуул тогтолыг их бага аль нэгэн хэмжээгээр гажуудуулах боломжийг нээсэн учир монгол хэлний мэргэжлийн үүднээс "сонгодог" гэж тодорхойлоход учир дутагдалтай санагдана.

3. "Сонгодог монгол бичигийн хэл" нь шашин сурталын хүрээнийхэнд даган мөрдөх хэм хэмжээ болж хэвшсэнийг орчуулгын зохиолуудаас гадна төвөдийн боловсролтон нарын монголоор бичсэн зохиол бүтээлээс харж болно. Үүнд дээр эшлэл авсан Лувсанданзаны "Алтан товч", "Хураангуй Алтан товч", Жамбын "Асрагч нэртийн түүх", "Шар тууж" зэрэг түүхийн зохиол, Данзандагвын "Зүрхэний

⁴⁶ Ц. Шагдарсүрэн, Монгол хэлний "тийн ялгал"-ын нэр томъёо, түүний гарлын асуудалд- *Mongolian Studies* (The Korean Association for Mongol Studies), N. 5 (1997), Seoul, 1998. pp. 257 (247 - 257).

толтын тайлбар" зэрэг бусад олон зохиолыг цувруулан дурдаж болно. "Сонгодог монгол бичигийн хэл"-ийг XVII зуунд хэвшин бүрэлдсэн гэж нийтээр хүлээн зөвшөөрдөг боловч XIV зууны бүр эхин үеийн Чойжидсэр зэрэг орчуулагчдын бүтээлд хэдийнээ ул мөрөө үлдээжгүй. Цаашилбал: "Монголын нууц товчоон"-ы сүүл хэсэгт үгийн байр болон найруулгын хувьд түрүүчийнхээ зүйлүүдээс ялгарсан, мөн түүнчилэн Бүддийн шашины мөнх бусын сургаалийг шүлэглэсэн хэсгийг мөр бадаг алдагдуулан хожим нэмсэн байж болзошгүй гэмээр баримт мэр сэр ажиглагддаг бөгөөд үүнээс үзэхүл "Монголын нууц товчоон" ганц зохиогчтой байх учиргүй гэдэг үзлийг давхар батлахын сац сүүлийн хэсгийг бичихэд тэр цагийн төвөд боловсролтон хүн оролцсон буюу засан найруулалцсан байх боломжтойг харуулж байж ч болзошгүй юм. Үүнийг цаашид нарийвчилан үзүүштэй зүйл гэж бодно.

4. XVII зууны түүхэн сурвалжийн судлагаанд дээрхи мэтийн өвөрмиц онцлогийг хэлшинжлэл болон логика хэмээх учир шалтгааны үүднээс бодолцохгүй болвоос буруу зөрүү ойлгох явдал ялангуяа шинэ залуу судлагч нарт гарч болзошгүй тул ийнхүү нуршин тэмдэглэж байна. Жишээлбэл:

Köbegün minü Toγan-i
Kümün-dür yakin jaruγulunam...⁴⁷

(Хүү минь Тогооныг
Хүнд яахин заруулнам...)

гэсэн өгүүлбэрийг хамбичвэр (Context)-ээс нь салгаж авсан тохиолдолд, төвөд хэлний найруулгын хэлбэр туссан гэдгийг эс анхаарах аваас энэхүү хоёр мөр бичвэрт хоёр хүний тухай буюу өгүүлэгчийн хандан хэлж буй "хүү" гэж нэг хүн байна, Тоγан гэж бас өөр нэг хүн байна гэж эдүүгээчилэн ойлгоход хүрнэ. Уг санааг одоогийн хүмүүст зөв ойлгогдохоор буулгана гэвэл даруй:

Хүү Тогооныг минь
Хүнд яахин зар(цл)уулнам

гэж найруулах хэрэгтэй болно. Харин түрүү үеийн судлагчид маань дээр эш татсан шиг, найруулгын хувьд төвөд хэлзүйн нөлөө үлэмжхэн туссан өгүүлбэрүүдийг хамбичвэрийн утга болон учир шалгааны үүднээс нь авч үзээд зөв ойлгосоор ирсэн боловч найруулгын ийм өвөрмиц зүйл байдаг талаар тусгайлан тайлбарласан бүтээл энэ хэр гараагүй ажээ.

2001 оны 3-5-р сар.

⁴⁷ Byamba, *Asaraγā neretü-yin teüke*, Улаанбаатар, 1960, 52.

